



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/12/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг
түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg@audit.gov.mn
Аудитор: Б.Отгон-Өлзий
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.28

№ 1-6/156

танай _____-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
АЛТАНШИРЭЭ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
М.ОДОНЧИМЭГ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга М.Одончимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 сарын 27-ны өдрөөс 2020 оны 01 сарын 29-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 01 сарын 29-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанширээ сумын Эрүүл мэндийн төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 28-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь Сум орон нутгийн хүн амын хэрэгцээнд нийцсэн түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй, цаг алдалгүй чанартай эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үзүүлэхэд оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг дунд гэж үнэллээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 311,572.3 мянган төгрөгөөс тооцон 6,231.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 229,534.3 мянган төгрөгөөр буюу 62.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	246,5	246.5	
Урьдчилгаа			
Бараа материал	19,004.0	30,166.1	11,162.1
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	365,312.9	594,847.2	229,534.3
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	365,312.9	594,847.2	229,534.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	365,312.9	594,847.2	229,534.3

Авлага дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна..

Бараа материалын дансны үлдэгдэл 11,162.1 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын үлдэгдэл 4,398.1 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материалын үлдэгдэл 205.5 мянган төгрөгөөр, аж ахуйн материалын үлдэгдэл 1,441.8 мянган төгрөгөөр, түлш, шатах тослох материалын үлдэгдэл 5,049.0 мянган төгрөгөөр, хүнсний материалын үлдэгдэл 67.8 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны олон жилээр хадгалагдсан, шаардлага хангахгүй материал байхгүй. Шинээр бэлтгэсэн материалууд нь зайлшгүй хэрэглэгдэхээр байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 229,534.3 мянган төгрөгөөр өссөн нь барилга 242,609.1 мянган төгрөгөөр өсч, тоног төхөөрөмж 5,868.7 мянган төгрөгөөр, тавилга хэрэгсэл 559.3 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 242,609.1 мянган төгрөгийн эмнэлгийн өргөтгөлийн барилга баригдаж ашиглалтанд орсон байна.

Алтанширээ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 03 сарын 25-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 6,428.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсныг устган данснаас хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 594,847.2 мянган төгрөг болж, 229,534.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 229,534.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвд тайлант онд орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 301,998.9 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 276,285.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,343.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулахад:

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,982.6	195,982.6	0.0	100.0
2	НДШ-ийн зардал	24,389.4	24,389.4	0.0	100.0
3	Гэрэл, цахилгаан	1,395.0	1,396.1	1.1	100.1
4	Түлш, халаалт	9,300.0	9,453.0	153.0	101.6
5	Цэвэр, бохир ус	360.0	196.8	-163.2	54.7
6	Бичиг хэрэг	1,500.0	1,820.0	320.0	121.3
7	Тээвэр, шатахуун	14,046.5	14,046.0	-0.5	100.0
8	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	800.0	900.6	100.6	112.6
9	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200.0	2,242.6	42.6	101.9
10	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,000.0	121.7	-878.3	12.2
11	Эм боох эмнэлгийн хэрэгсэл	22,655.2	22,593.7	-61.5	99.7
12	Хоол хүнс	5,000.0	3,355.6	1,644.4	67.1
13	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,500.0		1,500.0	0.0
14	Багаж, техник, хэрэгсэл	1,000.0	995.0	-5.0	99.5
15	Урсгал засвар	1,240.0	1,173.0	-67.0	94.6
16	Дотоод албан томилолт	1,000.0	846.4	-153.6	84.6
17	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	12,588.4	12,151.1	-437.3	96.5
18	Бараа үйлчилгээний бусад зардал	6,041.8	6,041.4	-0.4	100.0
	Нийт зардлын дүн	301,998.9	297,705.0	4,293.9	98.6

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 297,705.0 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цэвэр бохир усны зардлыг 163.2 мянган төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардлыг 878,3 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 1,644.4 мянган төгрөгөөр, нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардлыг 1,500.0 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 153.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 437.3 мянган төгрөгөөр хэмнэж, түлш халаалтын зардлыг 153.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 320.0 мянган төгрөгөөр, шуудан холбоо интернетийн зардлыг

100.6 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн боловч нийт зардлыг бүлэг дотор нь шилжүүлэн 4,293.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлтийн харилцах дансанд орлого төвлөрөөгүй байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 1 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 2 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 3,738.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 42.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 3696.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3,738.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 42.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1 Засвартай томилолтын хуудсаар томилолтын зардал 42.0 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, УСНББОУС-тай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 3,696.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын нягтлан бодогч тайлант хугацааны эцэст өөрчлөгдсөнтэй холбоотой харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн байдал, үндсэн хөрөнгө, бараа материалыг ангиллын дагуу бүртгэсэн эсэхийг нягталж үзэх.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 108 мэдээллийг хугацаанд нь, 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өнгөрсөн онд тайлангийн хугацаа хоцроосон тул хязгаарлалтай дүгнэлт авч, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант оны эцэст шатахууныг их хэмжээгээр нөөцөлсөн байна.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1.1 Илрүүлэлт:

Эрх зүйн актын хэрэгжилтийн сорилоор 2019 оны эцэст их хэмжээний буюу 2000 литр шатахуун нөөцөлсөн зөрчил илэрлээ.

Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.5.2."Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" заалт тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгө ашиглагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Хэмнэгдсэн зардлыг тодорхойлох нэрийдлээр бараа материал нөөцлөхгүй байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжтэй танилцсан, хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2020 оны 05 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,250,525.00</u>	<u>30,412,644.30</u>
33	АВЛАГА	246,500.00	246,500.00
335	Бусад авлага	246,500.00	246,500.00
3351	Байгууллагаас авах авлага	57,500.00	57,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	189,000.00	189,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,004,025.00	30,166,144.30
351	Түүхий эд материал	2,694,400.00	7,092,479.30
35110	Тусгай зориулалттай материал	2,694,400.00	2,694,400.00
35130	Эм боох материал	00.00	4,398,079.30
354	Хангамжийн материал	16,309,625.00	23,073,665.00
35410	Бичиг хэргийн материал	294,000.00	499,500.00
35420	Аж ахуйн материал	13,897,215.00	15,339,015.00
35440	Түлш, шатах тослох материал	1,155,000.00	6,204,000.00
35460	Хүнсний материал	963,410.00	1,031,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>346,062,405.79</u>	<u>564,434,601.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	346,062,405.79	564,434,601.81
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	335,330,405.79	553,702,601.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	244,006,790.00	486,615,874.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-8,175,094.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,599,990.00	49,599,990.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,803,330.04	-28,276,660.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,552,949.00	105,184,245.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,567,962.36	-60,613,044.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,141,272.00	17,281,997.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,775,229.26	-9,404,131.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,702,744.00	2,822,744.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,526,817.55	-1,333,316.85
393	Биет бус хөрөнгө	10,732,000.00	10,732,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,732,000.00	10,732,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>365,312,930.79</u>	<u>594,847,246.11</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>365,312,930.79</u>	<u>594,847,246.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	365,312,930.79	594,847,246.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	214,812,011.44	214,812,011.44
51101	Өмч: - төрийн	204,080,011.44	204,080,011.44
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	10,732,000.00	10,732,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-241,725,240.48	-12,190,925.16
51210	Өмнөх үеийн үр дүн	-262,480,200.25	-241,725,240.48
51220	Тайлант үеийн үр дүн	20,754,959.77	229,534,315.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	392,226,159.83	392,226,159.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>365,312,930.79</u>	<u>594,847,246.11</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	146,366,544.00	541,106,593.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,893,244.00	242,886,233.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,893,244.00	242,886,233.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,893,244.00	242,886,233.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,666,744.00	242,886,233.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	115,473,300.00	298,220,360.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	115,473,300.00	276,285,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	115,473,300.00	276,285,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	296,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	150,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	146,500.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	12,295,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	12,295,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	9,343,160.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	9,343,160.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	127,180,555.73	309,969,991.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,180,555.73	309,969,991.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,180,555.73	309,454,670.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	75,372,015.00	195,645,562.00
210101	Үндсэн цалин	74,580,016.00	185,353,898.00
210102	Нэмэгдэл	00.00	7,775,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	926,000.00
210104	Урамшуулал	791,999.00	1,590,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,926,030.00	25,795,249.00
210201	Тэтгэврийн даатгал	4,496,999.00	17,239,546.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,187,170.00	2,139,051.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	597,829.00	1,711,241.00
210204	Ажилгүйдлийн даатгал	149,457.00	427,312.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,494,575.00	4,278,099.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,955,572.00	9,692,877.00
210301	Гэрэл, цахилгаан	474,582.00	1,337,627.00
210302	Түлш, халаалт	6,374,800.00	8,100,000.00

**Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210303	Цэвэр, бохир ус	106,190.00	255,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,728,625.00	14,788,370.00
210401	Бичиг хэрэг	780,290.00	1,589,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,168,600.00	10,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	265,525.00	900,570.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	440,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	454,210.00	1,507,400.00
2105	Нормативт зардал	10,253,569.00	19,900,575.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,476,209.00	16,612,765.70
210502	Хоол, хүнс	1,777,360.00	3,287,810.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	190,000.00	1,173,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,173,000.00
2107	Томилолт, зочны зардал	366,700.00	846,400.00
210702	Дотоод албан томилолт	366,700.00	846,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,283,841.00	11,082,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,947,741.00	10,815,310.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,100.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	7,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,104,203.73	30,530,326.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,552,050.00	5,695,725.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,552,153.73	24,834,601.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	515,321.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	515,321.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	515,321.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>19,185,988.27</u>	<u>231,136,601.64</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-26,872,699.97	00.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-26,872,699.97	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-26,872,699.97	1,602,286.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-26,872,699.97	1,602,286.32
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>19,185,988.27</u>	<u>229,534,315.32</u>



 117144353
 E-DA0056 982570

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	236,905,250.00	298,220,360.00	
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,426,750.00	00.00	
120	Нийтлэг татварын бус орлого	1,426,750.00	00.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,426,750.00	00.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,426,750.00	00.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,478,500.00	298,735,681.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	235,478,500.00	276,285,500.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	235,478,500.00	276,800,821.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	296,700.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	150,200.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	146,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	12,295,000.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	12,295,000.00	
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	515,321.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	9,343,160.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	9,343,160.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	235,935,250.00	296,020,360.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,935,250.00	296,020,360.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	235,862,861.00	295,505,039.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,765,000.00	195,982,600.00	
210101	Үндсэн цалин	147,951,398.00	185,690,936.00	
210102	Нэмэгдэл	00.00	7,775,000.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	926,000.00	
210104	Урамшуулал	1,813,602.00	1,590,664.00	
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,053,036.00	24,389,400.00	
210201	Тэтгэврийн даатгал	12,952,370.00	16,742,000.00	
210202	Тэтгэмжийн даатгал	1,525,167.00	1,911,800.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,220,133.00	1,529,500.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	305,033.00	382,400.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,050,333.00	3,823,700.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,924,860.00	11,045,877.00	
210301	Гэрэл, цахилгаан	1,182,670.00	1,396,127.00	
210302	Түлш, халаалт	9,290,000.00	9,453,000.00	

**Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210303	Цэвэр, бохир ус	452,190.00	196,750.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,377,065.00	19,130,970.00
210401	Бичиг хэрэг	1,302,670.00	1,820,100.00
210402	Тээвэр, шатахуун	10,518,600.00	14,046,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,791.00	900,570.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	914,004.00	2,242,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	121,700.00
2105	Нормативт зардал	23,540,000.00	25,949,246.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,208,000.00	22,593,696.00
210502	Хоол, хүнс	2,965,500.00	3,355,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,366,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,163,089.00	1,468,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	870,650.00	295,000.00
210604	Урсгал засвар	1,292,439.00	1,173,000.00
2107	Томилолт, зочны зардал	807,800.00	846,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	807,800.00	846,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,095,281.00	12,151,121.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,340,779.00	11,884,121.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	570,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	66,100.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	7,000.00
210807	Газрын төлбөр	8,402.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,136,730.00	4,541,425.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,136,730.00	4,541,425.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,389.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,389.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,389.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	970,000.00	2,200,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	970,000.00	2,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	970,000.00	2,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	970,000.00	2,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	970,000.00	2,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-970,000.00	-2,200,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		


4417144353
E-A00056 9025707

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	204,080,011.44	261,859,976.08	-262,480,200.25	203,459,787.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	204,080,011.44	261,859,976.08	-262,480,200.25	203,459,787.27
C07	Тайлант үеийн үр дүн	10,732,000.00	00.00	19,185,988.27	29,917,988.27
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,812,011.44	392,226,159.83	-241,725,240.48	365,312,930.79
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,812,011.44	392,226,159.83	-241,725,240.48	365,312,930.79
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,812,011.44	392,226,159.83	-241,725,240.48	365,312,930.79
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	229,534,315.32	229,534,315.32
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,812,011.44	392,226,159.83	-12,190,925.16	594,847,246.11



 4417144355
 ЕҮОА0056 9025707


Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр / Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,998,900.00	297,705,039.00	-4,293,861.0	0.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,998,900.00	297,705,039.00	-4,293,861.0	0.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,998,900.00	297,705,039.00	-4,293,861.0	0.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,982,600.00	195,982,600.00	0.0	0.0
210101	Үндсэн цалин	149,995,000.00	185,690,936.00	35,695,936.0	0.0
210102	Нэмэгдэл	30,122,600.00	7,775,000.00	-22,347,600.0	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,165,000.00	926,000.00	-3,239,000.0	0.0
210104	Урамшуулал	11,700,000.00	1,590,664.00	-10,109,336.0	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,389,400.00	24,389,400.00	0.0	0.0
210201	Тэтгэврийн даатгал	16,742,000.00	16,742,000.00	0.0	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,911,800.00	1,911,800.00	0.0	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,529,500.00	1,529,500.00	0.0	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	382,400.00	382,400.00	0.0	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,823,700.00	3,823,700.00	0.0	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,055,000.00	11,045,877.00	-9,123.0	0.0
210301	Гэрэл, цахилгаан	1,395,000.00	1,396,127.00	1,127.0	0.0
210302	Түлш, халаалт	9,300,000.00	9,453,000.00	153,000.0	0.0
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	196,750.00	-163,250.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	19,546,500.00	19,130,970.00	-415,530.0	0.0
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,820,100.00	320,100.0	0.0
210402	Тээвэр, шатахуун	14,046,500.00	14,046,000.00	-500.0	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	900,570.00	100,570.0	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	2,242,600.00	42,600.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	121,700.00	-878,300.0	0.0
2105	Нормативт зардал	29,155,200.00	25,949,246.00	-3,205,954.0	0.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,655,200.00	22,593,696.00	-61,504.0	0.0
210502	Хоол, хүнс	5,000,000.00	3,355,550.00	-1,644,450.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	00.00	-1,500,000.0	0.0

**Дорноговь аймгийн Алтанширээ сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,240,000.00	2,168,000.00	-72,000.0	0.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	995,000.00	-5,000.0	0.0
210604	Урсгал засвар	1,240,000.00	1,173,000.00	-67,000.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	846,400.00	-153,600.0	0.0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	846,400.00	-153,600.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,588,400.00	12,151,121.00	-437,279.0	0.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,230,400.00	11,884,121.00	-346,279.0	0.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00	0.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	0.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	00.00	-68,000.0	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,000.00	7,000.00	-8,000.0	0.0
210807	Газрын төлбөр	15,000.00	00.00	-15,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6041800.00	6041425.00	-375.0	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,041,800.00	6,041,425.00	-375.0	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,998,900.00	297,923,660.00	-4,075,240.0	0.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	276,285,500.00	276,285,500.00	0.0	0.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	276,285,500.00	276,285,500.00	0.0	0.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,295,000.00	12,295,000.00	0.0	0.0
132001	Орон нутгийн төсвөөс	12,295,000.00	12,295,000.00	0.0	0.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,418,400.00	9,343,160.00	-4,075,240.0	0.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	13,418,400.00	9,343,160.00	-4,075,240.0	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00		0.6
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00		
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00		


 4417144353
 E-OA0056 9023707